БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/39/НА-СТА-ТШЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.vom

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2022 он

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь/
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
**4.1. Төлбөрийн акт ........ 16**
**4.2.Залруулсан алдаа**
**4.3. Зөвлөмж ........ 17**
**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/92

танай ____________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ГЭРЛЭЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020452

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **70.971.383.83** | **68.978.733.79** |
| **33** | **АВЛАГА** | 17.098.700.00 | 12.599.96 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 12.599.96 |
| **335** | **Бусад авлага** | 17.098.700.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 17.098.700.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 53.872.683.83 | 68.966.133.83 |
| **354** | **Хангамжийн материал** | 53.872.683.83 | 68.966.133.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 614.600.00 | 614.600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25.032.869.28 | 25.032.869.28 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 2.124.750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 28.225.214.55 | 41.193.914.55 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1.163.410.798.22** | **1.161.385.469.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1.163.410.798.22 | 1.161.385.469.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1.134.010.798.22 | 1.131.985.469.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1.185.101.395.76 | 1.185.101.395.76 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -79.225.796.28 | -119.536.319.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36.404.134.25 | 75.188.487.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -27.079.384.28 | -30.643.809.32 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24.468.413.80 | 29.903.413.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9.665.264.03 | -12.434.997.23 |
| 39217 | Ном | 4.007.299.00 | 4.407.299.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29.400.000.00 | 29.400.000.00 |
| 39301 | Програм хангамж | 00.00 | 150.000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -150.000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29.550.000.00 | 29.400.000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -150.000.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1.234.382.182.05** | **1.230.364.203.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **192.607.00** | **2.156.300.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 192.607.00 | 2.156.300.00 |
| **413** | **Өглөг** | 192.607.00 | 2.156.300.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 164.607.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 28.000.00 | 2.156.300.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1.234.189.575.05** | **1.228.207.903.65** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1.234.189.575.05 | 1.228.207.903.65 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 118.876.104.00 | 118.876.104.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 118.876.104.00 | 118.876.104.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 896.816.684.65 | 890.835.013.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 896.816.684.65 | 896.816.684.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5.981.671.40 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 218.496.786.40 | 218.496.786.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1.234.382.182.05** | **1.230.364.203.65** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **431.808.100.00** | **457.055.845.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5.388.500.00** | **8.490.000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5.388.500.00 | 8.490.000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5.388.500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5.388.500.00 | 00.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ | | **5.400.000.00** |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | | **3.090.000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **426.419.600.00** | **448.565.845.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378.373.800.00 | 395.908.200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5.562.200.00 | 14.252.840.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5.562.200.00 | 14.252.840.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 42.483.600.00 | 38.404.805.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42.483.600.00 | 38.404.805.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **470.978.330.18** | **463.037.516.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **470.978.330.18** | **463.037.516.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 458.419.415.70 | 447.316.102.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 272.808.498.00 | 281.055.319.00 |
| 210101 | Үндсэн цалин | 272.808.498.00 | 281.055.319.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34.267.339.00 | 37.139.050.03 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23.545.750.00 | 21.571.070.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2.704.642.00 | 7.358.060.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2.170.100.00 | 2.276.016.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523.328.00 | 539.559.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5.323.519.00 | 5.394.343.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36.931.323.52 | 40.061.105.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2.044.723.52 | 2.797.905.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34.303.500.00 | 36.263.200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 583.100.00 | 1.000.000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27.700.942.00 | 10.878.287.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 439.700.00 | 504.250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1.500.000.00 | 1.962.200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1.815.000.00 | 1.980.000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 647.000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240.000.00 | 120.000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23.706.242.00 | 5.664.837.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31.491.064.00 | 15.718.160.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 114.500.00 | 460.060.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28.258.152.00 | 15.090.600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3.118.412.00 | 167.500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7.578.200.00 | 9.066.500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1.782.000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7.578.200.00 | 7.284.500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 163.300.00 | 135.900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 163.300.00 | 135.900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 340.000.00 | 407.000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90.000.00 | 57.000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250.000.00 | 350.000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 47.138.749.18 | 52.854.781.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4.701.000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3.362.400.00 | 1.509.100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43.776.349.18 | 46.644.681.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12.558.914.48 | 15.721.414.01 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5.737.100.00 | 14.398.440.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5.562.200.00 | 14.252.840.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 174.900.00 | 145.600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4.552.276.48 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4.552.276.48 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2.269.538.00 | 1.322.974.01 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2.269.538.00 | 1.322.974.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-39.170.230.18** | **-5.981.671.40** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-39.170.230.18** | **-5.981.671.40** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **426,419,600.00** | **448,565,845.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **426,419,600.00** | **448,565,845.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,373,800.00 | 395,908,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,562,200.00 | 14,252,840.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,562,200.00 | 14,252,840.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 42,483,600.00 | 38,404,805.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 42,483,600.00 | 38,404,805.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **426,419,600.00** | **415,064,492.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **426,419,600.00** | **415,064,492.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **413,860,685.52** | **399,343,077.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 272,563,682.00 | 280,213,615.00 |
| 210101 | Үндсэн цалин | 181,430,113.74 | 213,988,622.00 |
| 210102 | Нэмэгдэл | 52,892,169.00 | 34,827,104.00 |
| 210104 | Урамшуулал | 38,241,399.26 | 31,397,889.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,391,654.00 | 38,157,960.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,675,086.00 | 26,770,597.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,720,079.00 | 2,847,706.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,170,100.00 | 2,276,016.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 502,771.00 | 568,211.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,323,618.00 | 5,695,429.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,931,323.52 | 37,904,805.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,044,723.52 | 2,797,905.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,303,500.00 | 34,106,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 583,100.00 | 1,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,857,300.00 | 10,205,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 156,500.00 | 731,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,962,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,435,100.00 | 1,740,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 87,500.00 | 216,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 197,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,438,200.00 | 5,358,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 41,359,826.00 | 18,485,210.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,565,200.00 | 617,060.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,230,326.00 | 17,215,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,564,300.00 | 652,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,563,200.00 | 7,511,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,295,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 290,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,268,200.00 | 7,221,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 163,300.00 | 135,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 163,300.00 | 135,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,063,900.00 | 1,155,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 813,900.00 | 565,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,966,500.00 | 5,573,437.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 4,300,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,966,500.00 | 1,273,437.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,558,914.48** | **15,721,414.01** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,737,100.00 | 14,398,440.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,562,200.00 | 14,252,840.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 174,900.00 | 145,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,552,276.48 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,552,276.48 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,269,538.00 | 1,322,974.01 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,269,538.00 | 1,322,974.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **33,501,353.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **33,501,353.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **33,501,353.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 33,501,353.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 33,501,353.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-33,501,353.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бус ад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 118.876.104.00 | 218.496.786.40 | 935.986.914.83 | 0.0 | 1.273.359.805.23 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **118.876.104.00** | **218.496.786.40** | **935.986.914.83** | **0.0** | 1.273.359.805.23 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 15.106.070.00 | | 15.106.070.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **118.876.104.00** | **218.496.786.40** | **896.816.684.65** | **0.0** | 1.234.189.575.05 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **118.876.104.00** | **218.496.786.40** | **896.816.684.65** | **0.0** | 1.234.189.575.05 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **118.876.104.00** | **218.496.786.40** | **896.816.684.65** | **0.0** | 1.234.189.575.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5.981.671.40 | 0.0 | -5.981.671.40 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **118.876.104.00** | **218.496.786.40** | **890.835.013.25** | **0.0** | 1.228.207.903.65 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 438,020,300.00 | 432,990,030.99 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 438,020,300.00 | 432,990,030.99 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,874,700.00 | 432,844,430.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 280,855,700.00 | 280,213,615.00 |
| 210101 | Үндсэн цалин | 209,448,300.00 | 213,988,622.00 |
| 210102 | Нэмэгдэл | 34,336,800.00 | 34,827,104.00 |
| 210104 | Урамшуулал | 37,070,600.00 | 31,397,889.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,444,700.00 | 38,157,960.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,053,600.00 | 26,770,597.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,847,800.00 | 2,847,706.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,278,300.00 | 2,276,016.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 569,500.00 | 568,211.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,695,500.00 | 5,695,429.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,612,100.00 | 37,904,805.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,956,400.00 | 2,797,905.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,655,700.00 | 34,106,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,188,400.00 | 14,047,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 731,100.00 | 731,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 1,962,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,743,600.00 | 1,740,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 572,800.00 | 516,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 197,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,900,900.00 | 8,900,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,646,300.00 | 18,485,210.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 618,000.00 | 617,060.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,375,400.00 | 17,215,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 652,900.00 | 652,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,073,300.00 | 37,070,453.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,000,000.00 | 24,997,153.00 |
| 210602 | Тавилга | 2,800,000.00 | 2,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,273,300.00 | 9,273,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 135,900.00 | 135,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 135,900.00 | 135,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,280,200.00 | 1,255,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 690,200.00 | 665,450.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5638100.00 | 5573437.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,300,000.00 | 4,300,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,338,100.00 | 1,273,437.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 145600.00 | 145600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 145,600.00 | 145,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 145,600.00 | 145,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 438,020,300.00 | 432,990,030.99 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 395,908,200.00 | 394,585,225.99 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 395,908,200.00 | 394,585,225.99 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 42,112,100.00 | 38,404,805.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,112,100.00 | 38,404,805.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 27.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 18.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08.00 | 08.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5562200.00 | 14252840.00 |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5562200.00** | **14.252.840.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5562200.00** | **14.252.840.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **55622000.00** | **14252840.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **55622000.00** | **14.252.840.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5562200.00 | 14.252.840.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5562200.00** | **14252840.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5562200.00** | **14.252.840.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5562200.00 | 14.252.840.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж

заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Б.Гэрлээ нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бууцагаан сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэх зорилго зорилтыг хангах үүднээс сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн Б/25 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 470,978.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,064.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,298.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 5,209.2 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,230,364.2 мянган төгрөг болж өмнөх оноос 4,018.0 мянган төгрөгөөр буюу 0,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсантай холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 70.971.4 | 68.978.7 | (1.992.7) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 17.098.7 | 12.6 | (17.086.1) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 53.872.7 | 68.966.1 | 15.093.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1.163.410.8 | 1.161.385.5 | (2.025.3) |
| Үндсэн хөрөнгө | 1.279.531.2 | 1.324.150.6 | 44.619.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (116.120.4) | (162.765.1) | (46.644.7) |
| **Нийт хөрөнгө** | 1.234.382.2 | 1.230.364.2 | (4.018.0) |
| Өр төлбөр | 192.6 | 2.156.3 | 1.963.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1.234.189.6 | 1.228.207.9 | (5.981.7) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1.234.382.2 | 1.230.364.2 | (4.018.0) |

Бараа материалын дансны үлдэгдэл 68,966.1 мянган төгрөг болж 15,093.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 12,968.7 мянган төгрөг, хүнсний материал 2,124.5 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,324,150.6 мянган төгрөг болж 44,619.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 36,884.3 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 1,935.0 мянган төгрөгөөр тавилга, 400.0 мянган төгрөгөөр ном худалдан авч, 1,900.0 мянган

төгрөгийн тоног төхөөрөмж, 3,500.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хандиваар авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,228,207.9 мянган төгрөг болж өмнөх оноос 5,981.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 14,252.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 891,742.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 891,742.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 435,804.9 мянган төгрөгөөр бууруулж 455,937.9 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 438,020.3 мянган төгрөг болж 17,917.6 мянган төгрөг буюу 3.9 хувиар буурч батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 438,020.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 395,908.2 мянга, орон нутгийн төсвөөс 42,112.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 395,908.2 мянга, орон нутгийн төсвөөс 38,404.8 мянга нийт 434,313.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 432,990.0 мянган төгрөгийг зарцуулж 1,323.0 мянган төгрөг буюу 0.3 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 3,707.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 432,990.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа тогтмол зардлыг 999.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 14,252.8 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Баянташаагийн эх" ХХК –ний аудитор Т.Хоролсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 34 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 94 %-тай гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 463,037.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7,940.8 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ийн зардал 11,118.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,129.8 мянган төгрөгөөр өсөж, нормативд зардал 15,772.9 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 41,612.1 мянган төгрөг батлагдсан гүйцэтгэлээр 3,707.3 мянган төгрөгийн хэмнэсэн нь дээрх тогтоолын дахь заалттай нийцэхгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 78,734.7 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулж,эхний хагас жилд "Мөнхийн хүч" хоршоо , сүүлийн хагас жилд "Дархан сүрэг" хоршоотой гэрээ байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн зөвлөмж өгсөн боловч тайлант онд цалингийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,508.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч, 6,691.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 4,816.8 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, зөрчлийг дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгөв.

### 4.1. Төлбөрийн акт

**4.1.1**. Багш ажилтнуудын хоолны зардлын төсөв батлагдаагүй байхад эрхлэгчийн 2021.10.22-ны Б/16, 2021.11.22-ны Б/18 тоот тушаалаар 6,691.5 мянган төгрөгийн хоолны мөнгө цалингийн зардлаас үндэслэлгүйгээр өндөр дүнгээр олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай " Сангийн сайдын 2021.10.29-ний 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчсөн, Санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Ажилтнуудад олгосон 6,691.5 мянган төгрөгийг суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.2.Залруулсан алдаа

**4.2.1.** Горим сорил гүйцэтгэх явцад дараах алдаа, илэрлээ . Үүнд:

-2021 оны 12 дугаар сарын халаалтын зардлыг 2,156.8 мянган төгрөгөөр дутуу шилжүүлээд өглөгөөр тусгаагүй.

- 2021.12.23-нд Жойфүл дэсэндэнүс ХХК-иас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,250.0 мянган төгрөгийн үнэтэй ус цэвэршүүлэгч, 1,260.0 мянган төгрөгийн үнэтэй шүүлтүүр зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг хангамжийн материалд орлого авсан.

- Санхүүгийн тайланд программ хангамж түүний хуримтлагдсан элэгдлийг бусад биет бус хөрөнгөнд бүртгэж тайлагнасан атлаа Э тайланд программ хангамж дансанд бүртгэсэн зэргээс 4,816.8 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

Энэ нь санхүүгийн тайлагналын “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна. гэснийг үндэслэн санхүүгийн тайланд 4,816.8 мянган төгрөгийг залруулав.

### 4.3. Зөвлөмж

**4.3.1.** Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 41,612.1 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 8,322.4 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 3,707.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Цаашид дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бууцагаан сумын Цэцэрлэг | 5 | 11,508.3 | 3 | 4,816.8 | 1 | 6,691.5 | | | 1 | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

______oOo______